



ПЛАТИНУМ ЛАНД ХХК
“ТУУЛЫН ЗҮҮН ДЭНЖ 1-3” ТӨСӨЛ



**БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ТУУЛЫН ЗҮҮН
ДЭНЖ 1-3 ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он



**БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТУУЛЫН ЗҮҮН
ДЭНЖ 1-3” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**
/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-000181
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5076285/

ХЯНАСАН:

БОУАӨЯ-НЫ ХБОБХГ-ЫН ДАРГА

...../Г.ЭНХМӨНХ/

БОУАӨЯ-НЫ ХБОБХГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ПЛАТИНУМ ЛАНД” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

“ПЛАТИНУМ ЛАНД” ХХК-ИЙН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

...../Ц.ЖАРГАЛНЭМЭХ/



...../Г.ТӨРМӨНХ /

...../Э.ЧИНБАТ /

ГАРЧИГ

ГАРЧИГ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	1
1.3. Уур амьсгалын улирлын ерөнхий горим.....	3
1.3.1. Уур амьсгалын нөхцөл.....	4
1.4. Усан орчин.....	7
1.5. Хөрсөн бүрхэвч	7
1.6. Ургамлан нөмрөг.....	8
1.7. Амьтны аймаг	8
БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
2.1. Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	17
2.2. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	17
2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	18
2.4. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах	19
2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	21
2.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	22
2.7. Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	23
2.8. Дуу чимээнээс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	24
БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
3.1. Биологийн нөхөн сэргээлт	25
БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛСТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ	29
БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	32

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	34
9.1. Агаарын чанарын хяналт.....	34
9.2. Усны эрүүл ахуй, чанар:	35
9.3. Хөрсний эрүүл ахуй, чанар:.....	36
БҮЛЭГ 10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	37
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	39
БҮЛЭГ 12. ТЭР БУМ МОДНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ.....	41
Мод үржүүлгийн аж ахуй	43
БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	45
ДҮГНЭЛТ.....	47

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1.1. Талбайн солбицлын цэгүүд /MV-000181/.....	2
Хүснэгт №1.2. Хөрсний гадаргын температур	6
Хүснэгт №2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	9
Хүснэгт № 4.1. Булгийн эхийг хашсан ажлын зардал.	27
Хүснэгт № 7.1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.	30
Хүснэгт № 8.1. Хог хаягдлын сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө.	32
Хүснэгт № 12.1. Бүрэгхангай суманд мод тарьсан ажлын зардал.....	43
Хүснэгт № 12.2. Модны үрийн зардал.....	45
Хүснэгт № 13.1. БОМТ-ний төсвийн задаргаа.	45

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График № 9.1. Зам усалгаа хийгдсэн усны зарцуулалт.....	34
---	----


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1.1. Байршлын тойм зураг.....	1
Зураг № 2.2. Технологийн зам усалгаа хийгдэж буй байдал.	17
Зураг № 2.3. Кемпийн орчны тохижилт, ногоон байгууламж.....	18
Зураг № 2.4. Уурхайн технологийн зам арчилгаа.	18
Зураг № 2.5. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй байдал.	19
Зураг № 2.6. Хөрсөн бүрхэвчийг хамгаалж биологийн нөхөн сэргээлт хийсэн байдал.	19
Зураг № 2.7. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ	20
Зураг № 2.8. Усны дээжийг авч буй байдал.....	21
Зураг № 2.9. Бохир ус соруулж буй байдал.....	21
Зураг № 2.10. Ургамлын хэмжилт хийлгэж буй байдал.	22
Зураг № 2.11. Хайлаас болон мандлын цэцгийн үр түүж буй байдал.	22
Зураг № 2.12. Мал усруу явах хэсгийг аюул эрсдэлгүй болгосон байдал.....	23
Зураг № 2.13. Эргэлтийн усан санд үржсэн загасыг голруу нүүлгэн шилжүүлж буй байдал.	23
Зураг № 2.14. Эмчийн үзлэгт хамрагдаж буй байдал.	24
Зураг № 2.15. Малчдын өвөлжөөний бууцыг хуулж өгсөн байдал.....	24
Зураг № 3.1. Биологийн нөхөн сэргээлт хийгдэхээр төлөвлөсөн талбай.....	25
Зураг № 3.2. Биологийн нөхөн сэргээлт хийж буй байдал.	26
Зураг № 4.1. Булгийн эхийг хашиж орон нутагт хүлээлгэн өгөв.....	28
Зураг № 9.1. Технологийн зам усалгаа хийгдэж буй байдал.	34
Зураг № 9.2. Гадаргын болон гүний уснаас дээж авч шинжилгээнд хамруулсан байдал...	35
Зураг № 9.3. Засвар болон хог хаягдлын цэгээс дээж авч шинжилгээнд хамруулсан байдал.	36
Зураг №10.1. Олон улсын аудитын шалгалтын үйл явц.....	37
Зураг №10.2. “Монголын цахим институт” ТББ-ын сургалтын үйл явц.....	38
Зураг № 10.3. Нийгмийн хариуцлагын гэрээ.....	39
Зураг № 11.1. Багийн хуралд танилцуулга тавьж буй байдал.	39
Зураг № 11.2. Булган аймгийн байгаль орчны газрын ажлын хэсэг нөхөн сэргээлт хэсэг нэгжийн үйл ажиллагаатай танилцсан байдал.....	40
Зураг №11.3. Туул голын сав газрын захиргаанаас хяналт шалгалтыг явуулсан байдал.....	40
Зураг №12.1. Мод үржүүлгийн талбайгаас суулгац хурааж буй байдал.....	41
Зураг №12.2. Бүрэгхангай суманд мод тарих газрын байршил.....	42
Зураг №12.3. Мод тарьж буй байдал.....	42
Зураг №12.4. Хашаа хамгаалалтыг хийж, модны усалгаа хийж буй байдал.....	42
Зураг № 12.5. Мод үржүүлгийн ажлын үйл явц.	44

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Туулын зүүн дэнж 1-3 хэсэг” орд нь Булган аймгийн Бүрэгхангай сумын 3 дугаар багийн нутагт харъяалагдах бөгөөд Бүрэгхангай сумын төвөөс 40 орчим км, Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 240 км, Дархан хотоос 240 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс 35 км зайд оршино. Хамгийн ойрхон суурин газар нь Заамар сумын Өгөөмөр багаас 4 км зайтай байна.



Зураг № 1.1. Байршлын тойм зураг

Газрын гадарга нь Хангай Хэнтийн уулархаг их мужид хамрагдана. Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлийг бий болгодог. Үүний ачаар хөрс харьцангуй зузаан бөгөөд ялзмаг болон тэжээлийн бодис ихтэй байна. Уулархаг гадаргын улмаас хөрсний бүсшил бий болж, ялангуяа уулсын ар, сүүдэр хажууд тод илэрнэ. Тус нутгийн уул нурууд далайн түвшнээс дээш дунджаар 1300-1400м өндөр, харин тал хөндий хэсэгтээ далайн түвшнээс дээш 1100-1200 орчим метр өндөрт өргөгдсөн.

Хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600 км орчим урттай, 1-4 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Гольдрол нь тохойрол, тахирлалд ихтэй, олон тооны хар ус, жижиг аралтай бөгөөд гольдрлын өргөн нь 30-100 м, гүн нь 0.5-1.6 м зарим газраа 2.5 м хүрдэг. Урсгалын хурд 0.3-11 м/сек, хөндийн хэвгий нь 0.001-0.002.градус байна.

Цаг агаарын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь +2.8°C байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар ба агаарын хэм нь -37°C, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар ба агаарын хэм нь +40 С хүрдэг.



Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80% нь зуны улиралд бороо байдлаар ордог. Өвөл нь 5-25 см цасан бүрхүүл тогтож улирлын хөлдөлтийн гүн 2.5 м хүрдэг ба голчлон баруун өмнөөс 5-10 м/с салхи салхилдаг. Заримдаа 20 м/сек хүрэх удаа бий. Туул гол 10 дугаар сарын сүүлчээр хөлдөж эхлэх ба 4 дүгээр сарын эхээр гэсч эхэлдэг. Газрын доорх ус агуулсан үе нь 6-30 м-ийн гүнд орших ба ойролцоогоор 3 л/сек ундаргатай байдаг.

Техникийн болон ахуйн хэрэгцээний усыг хөрсний усаар болон Туул голоос, харин ахуйн хэрэгцээний усыг уурхайн тосгоны ойролцоо орших өрөмдмөл худгийн газрын доорх усаар хангана.

Хүснэгт № 1.1. Талбайн солбицлын цэгүүд /MV-000181/.

MV-000181 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл Туулын зүүн дэнж					
д/д	Уртраг	өргөрөг	д/д	Уртраг	өргөрөг
1	104° 23' 29.05"	48° 18' 06.82"	13	104° 23' 45.96"	48° 18' 19.41"
2	104° 23' 21.93"	48° 18' 06.82"	14	104° 23' 43.93"	48° 18' 13.71"
3	104° 23' 21.93"	48° 18' 41.81"	15	104° 23' 43.20"	48° 18' 13.68"
4	104° 23' 32.93"	48° 18' 41.81"	16	104° 23' 41.39"	48° 18' 13.49"
5	104° 23' 32.93"	48° 18' 01.82"	17	104° 23' 39.28"	48° 18' 13.12"
6	104° 23' 02.36"	48° 18' 51.80"	18	104° 23' 37.40"	48° 18' 12.64"
7	104° 23' 57.83"	48° 18' 42.45"	19	104° 23' 35.36"	48° 18' 11.92"
8	104° 23' 56.04"	48° 18' 35.33"	20	104° 23' 33.61"	48° 18' 11.09"
9	104° 23' 56.04"	48° 18' 29.80"	21	104° 23' 32.72"	48° 18' 10.55"
10	104° 23' 52.84"	48° 18' 29.80"	22	104° 23' 31.97"	48° 18' 10.02"
11	104° 23' 54.55"	48° 18' 27.90"	23	104° 23' 30.92"	48° 18' 09.13"
12	104° 23' 46.91"	48° 18' 20.38"	24	104° 23' 29.89"	48° 18' 08.01"
Нийт				85.39 га	



1.3. Уур амьсгалын улирлын ерөнхий горим

Булган аймгийн нутаг нь Хангай, Хөвсгөлийн уулархаг мужид орших учир хойд талаараа Хантай /2000м/, Бүтээл /1800 м/ нутгийн төв хэсгээрээ Бүрэн /1986м/, өмнө хэсгээрээ Бүрэг /1600-2000м/ далайн түвшнээс дээш өргөгдсөн уул нуруудтай ерөнхийдөө хээрийн бүс нутагт хамрагддаг.

Газрын хотгор гүдгэр уул нурууны өндөр нам, хэлбэр дүрсээс шалтгаалж агаар мандалд орон нутгийн чанартай өгсөх уруудах хөдөлгөөн үүсэх, мөн хур тунадасны тархалтанд нөлөөлөн салхины чиглэл хурд зэрэг нь харилцан адилгүй байдаг.

Нарны цацрагийн жилийн явцаас хамааран аймгийн нутагт жилийн 4 улирал солигддог. Гэхдээ тухайн орон нутгийн хотгор гүдгэр /уул, нуруу, тал, хөндий/ дэвсгэр гадаргын шинж /ой, хөвч, намаг, нуур гэх мэт/ зэргээс шалтгаалан улиралын шинж газар бүр харилцан адилгүй илэрнэ. Улиралын ялгааг тогтооход дулааны горимоор буюу агаарын хоногийн дундаж температур тодорхой заагийг давж тогтвортой дээшлэх, доошлох хугацааг гол үзүүлэлт болгон авч байна.

Өвөл: Өвлийн улирал дунджаар 11-р сарын 9-ний үеэс эхлэн 3-р сарын 14 хүртэл дунджаар 126 хоног үргэлжилнэ. Өвөл ихэнхдээ тэнгэр цэлмэг, тогтвортой хүйтэн, цас бага, салхины хүч бага байна. Хамгийн хүйтэн 1 сарын агаарын дундаж температур нь -16.5...-26.4 градус байдаг бөгөөд үнэмлэхүй хамгийн бага температур -45-46 градус хүрнэ. Харьцангуй чийгшил хамгийн их утгандаа хүрэх ба 1 сард дунджаар 1.3 мм хур тунадас ордог. Өвөл тус аймгийн нутагт баруун хойд зүгийн салхи зонхилох ба дунджаар 1.9-2.5 м/с салхи салхилна. Тогтвортой цасан бүрхүүл 2-р сарын хоёрдугаар 10 хоногоос 3-р сарын гуравдугаар 10 хоног хүртэл үргэлжилнэ.

Хавар: Хавар 3-р сарын 15-аас 5-р сарын 10 хүртэл дунджаар 55 хоног үргэлжилнэ. Хавар цаг агаарын байдал тогтворгүй, агаарын температур түргэн нэмэгдэж, өдөртөө дулаан, шөнөдөө хүйтэн, нэг хоногийн доторхи халуун хүйтний хэлбэлзэл их болно. 3 дугаар сар нийтдээ хүйтэвтэр бөгөөд сарын дундаж агаарын температур -5.3...-11.7 байснаа 4-р сараас эхлэн 0 градусаас дээшилж 5-р сарын дундаж температур 8.7...13.5 градус хүрч дулаарна. Энэ улиралд салхины хурд ихсэж дунджаар 2.5...3 м/с болдог бөгөөд шороон шуурга олонтоо шуурдаг ба дунджаар 5-6 өдөр шуурна. Эрс тэс уур амьсгалтай хоногийн температурын хэлбэлзэл их учир хаврын сүүл, намрын эхээр цочир хүйтрэл болох нь олширно.

Зун: Зуны улирал 5-р сарын 11-ээс 9-р сарын 20 хүртэл дунджаар 133 хоног үргэлжилнэ. Хамгийн дулаан 7-р сарын дундаж температур 16.9 дулаан, үнэмлэхүй халуун нь 40.5 градус хүрч дулаарна. Харьцангуй чийгшил 8-р сард 67-71% болно.

Намар: Намрын улирал 8-р сарын 20-ны үеэс 11-р сарын 21-ний үе хүртэл дунджаар 63 хоног үргэлжилнэ. Намрын улиралд агаарын температурын хэлбэлзэл их боловч хаврынхтай адил биш 10-р сарын дундаж температур 0.7 градус байдаг. Намрын улиралд цаг агаар тогтворгүй болж салхины хүч нэмэгдэн сарын дундаж салхины хурд 1.0-3.0 м/с хүрэх боловч хаврынхад үл хүрнэ. Тус аймгийн нутагт анхны цочир хүйтрэл дунджаар 8-р сарын 31-нээс 9-р сарын 18-ны хооронд байна.

Газар зүйн өргөрөг ихсэх тутам нарны эрчим багасдаг ерөнхий зүй тогтолтой боловч, өргөрөгийн хоёр градусын хооронд орших нэг аймгийн нутагт өөрчлөгдөх нь бага,



харин нарны өндөр нам, гийгүүлэлтээс хамааран нэг өдөр болон нэг жилийн дотор тусах цацрагийн хэмжээ өөрчлөгддөгийн зэрэгцээ газар нутгийн хэвгий хазгай, ар энгэрийн байдал үүлшил, агаарын булингарлаас шалтгаалж харилцан адилгүй байна. Нарны нийлбэр цацраг 1300-1400 кВт цаг/м² буюу нийлбэр цацрагаар монгол орны дунд бүсэд оршдог.

Хоногийн дундаж температур +10°C-аас дээш байх өдөр Бүрэгхангай суманд 128 хоног байдаг ба +30 °C-аас халуун байх өдөр ойролцоогоор 4 удаа тохиолдоно. Нар гийгүүлэх нийт хугацаа 2745 цаг байна.

1.3.1. Уур амьсгалын нөхцөл

Агаарын температур: Агаарын температур нь тухайн орон нутгийн уул нуруу, хотгор гүдгэр, хөрсний байдал /өнгө, бүтэц, ургамлын өндөр нам, тархац цасан бүрхүүл/ зэргээс ихээхэн хамаарна. Агаарын температурын агаар мандлын төлөв байдлыг тодорхойлогч гол элемент, уур амьсгалын чухал нэг үзүүлэлт юм. Агаарын температурын хоногийн явцыг газрын гадаргаас дээш 2 метрийн өндөрт байрлуулсан термометр болон автомат станцуудаар тодорхойлж байна.

Тус аймгийн нутагт агаарын температур өмнөөсөө хойшлох тутам ерөнхийдөө буурах боловч гадаргын байдал орон нутгийн онцлогоос болж жигд биш хуваарилалттай байна.

Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур Эг, Эрингийн гол, Сэлэнгэ мөрний бэлчир, орхон голын орчмоор -21.5...-26.4 градус, бусад нутгаар -16.4...20.4 градус хүйтэн байна.

Жилийн хамгийн дулаан нь 7 дугаар сарын дундаж температур аймгийн өмнөд хэсэг, Эг Эрингийн сав газар Бүрэгхангай суманд 18.1...19.6 градус бусад нутгаар 16.1...17.9 градус дулаан байна.

Хөрсний гадаргын жилийн дундаж температур -0.0...+5.2 градус дулаан жилийн ундаж агаарын температурын утгаас бараг 4 градусаар дулаан байдаг. Хөрсний гадаргын сарын дундаж температур нь 2 дугаар сараас 3 дугаар сарыг дуустал 0 градусаас доош байх бөгөөд хамгийн хүйтэн 1 дүгээр сард -24.4...-27.1 градус, үнэмлэхүй хамгийн хүйтэн нь 46.5...48.9 градус байдаг.

Уулсын ба голын хөндий, хотгор газраа хүйтэн байх учраас хүйтний эрч газар нутгийн далайн түвшнээс дээших өндөр ихсэх тутам буурч байдаг.

Хавар намар хоногийн дундаж температур 0 градусаас дулаан байхад агаарын буюу хөрсний гадаргын температур 0 градус ба түүнээс доош орж хүйтрэхийг цочир хүйтрэл гэнэ. Тус суманд анхны цочир хүйтрэл дунджаар 9 сарын 5-нд болж хавар 5 дугаар сарын 16-нд дуусч хүйтрэлгүй хоногийн үргэлжлэх хугацаа дунджаар 91 хоног Булган аймгийн нутаг ерөнхийдөө чийглэгдүү нутагт орно. Хөрсний хаврын чийгийн горим нь намар, өвлийн хур тунадас чийг хангамжаас шалтгаална. Гол төлөв хөрс хөлдсөн хойно цасан бүрхүүл тогтдог /11-р сарын эхний 10 хоногт/ учраас хавар цас хайлахад түүний шар ус ихэвчлэн ууршиж алдагдах бөгөөд хөрсний чийгийн горимд бага нөлөөтэй. Хавар хөрс гэсэх үеэс хоногийн дундаж агаарын температур 5 градус болж дулаарахаас эхлээд хөрсний дээд давхаргын чийгийн нөөц ууршиж эрс буурч байдаг зүй тогтолтой.



Тус аймгийн нутагт жилд уулархаг хэсэгтээ 350 мм-ээс дээш голын хөндийд 250-300 мм өмнөд хэсгээр 200-250 мм хур тунадас унаж байна. Жилийн хур тунадасны 85 хувь нь зөвхөн жилийн дулаан улиралд оногдно. Хоногийн хамгийн их хур тунадас өвлийн улиралд 1.8-6 мм, хавар намрын саруудад 6.3-37.6 мм ажиглагдаж, хур тунадас элбэгтэй зуны саруудад хоногт 40.0-93.3 мм ажиглагджээ.

30 хувиас бага чийгтэй өдрийн тоо Бүрэгхангай суманд 21.4 өдөр байдаг ба жилдээ 237.0 мм тунадас ордог байна. Жилд унах тунадасны дийлэнх нь буюу 227.6 мм нь дулааны улиралд, 9.4 мм нь хүйтний улиралд ордог байна. Бороотой өдрийн тоо жилд дунджаар 46.2 өдөр байдаг. Хамгийн анхны цас олон жилийн дунджаар 10 сарын 02-нд, эцсийн цас дунджаар 5 сарын 16-ны хооронд ажиглагддаг. Жилийн 146.7 хоног цасан бүрхүүлтэй байдаг.

Энэ бүс нутгийн бас нэг онцлог нь монголын бусад нутгийн нэгэн адил нэг хоногт орсон тунадасны хэмжээ сарын нийлбэрээс давах тохиолдол байдаг. Тухайлбал 2006 оны VI сард нэг хоногт орсон тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 10.5 мм-ээр их хур тунадас орж байжээ.

Салхи: Салхи нь агаар мандлын орчил урсгал, тухайн орон нутгийн онцлогоос шалтгаална. Тус аймгийн нийт сумдын салхины чиглэл харилцан адилгүй давтагдалтай байдаг нь судалгаанаас харагддаг. Гэхдээ энд ерөнхий нэг онцлог байдаг нь станц харуулын салхины чиглэл гол мөрний хөндий, уулын амныхаа дагуу байдаг байна. Тус аймгийн нутгаар салхины дундаж хурд 2.2 м/с байдаг. Салхины хурд жил, улирал, хоногийн явцтай байдаг. Салхины хурдны жилийн явцыг үзвэл өвлийн улиралд манай орны нутагт төвтэй эсрэг циклон тогтвортой оршдог учир ихэвчлэн намуун хавар, намар тус улсын нутгийг дундад өргөргийн фронтын бүс хойш урагш дайран өнгөрөх учир цаг агаар ихээхэн тогтворгүй, салхи ихтэй болдог.

Салхины горим хурд, хөрсний байдалтай уялдан шороон шуурга болох нь газар бүр харилцан адилгүй ба олон жилийн ажиглалтаас хархад шороон шуурга жилд дунджаар 10 өдөр тохиолдонон. Тогтвортой цасан бүрхүүл тогтсон эсэхээс үл хамааран цасан шуургатай өдрийн тоо жилд дунджаар 2.4 өдөр байдаг ба хамгийн ихдээ 5.1 өдөр байдаг байна.

Булган аймгийн Бүрэгхангай сум нь уур амьсгалын мужлалын хувьд хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. Энэ орчмын уур амьсгалын үндсэн нөхцөл байдал нь хоног, сар, жилийн агаарын температурын агууриг их, агаарын чийгшил бага, хур тунадасны хуваарилалт жигд бус, зундаа их халж, өвөлдөө их хүйтрэх зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдоно. Судалгаагаар агаарын хамгийн хүйтэн 1 дүгээр сард -38°C бөгөөд 9 дүгээр сарын сүүлээс эхлээд хүйтэрч эхэлдэг. 3 дугаар сараас эхлэн мэдэгдэхүйц дулаарах хандлага гарах бөгөөд 4 дүгээр сард цасан бүрхүүл бүрмөсөн хайлж дуусна. Жилийн дундаж хур тунадас 330 мм болдог бөгөөд түүний 85% нь зуны улиралд ногддог. Төслийн талбайн хэмжээнд олон жилийн мөстлөг байхгүй боловч өвөл 2-2.5 м хүртэл хөрс хөлддөг.

Салхи голдуу хойт ба баруун хойт чиглэлтэй байх ба салхины дундаж хурд нь 3.5 м/с бөгөөд 3, 4 дүгээр саруудад салхины хурд 20 м/с хүрдэг. Сүүлийн 70 гаруй жилд Монгол Улсын хэмжээнд газрын гадарга орчмын агаарын жилийн дундаж температур 2.1°C дулаарч, жилд орох хур тунадасны хэмжээ 10% буурсан нь энэхүү бүсэд мөн



хамаарна. Эндээс харахад манай оронд гандах, хуурайших процесс эрчимтэй явагдаж байгаа бөгөөд цаашид хүний болон хүний оролцоогүйгээр үргэлжлэх үйл явц болоод байна. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ихсэх болсон. Иймээс цаг агаарын өөрчлөлт, байгалийн гэнэтийн гамшгаас урьдчилан сэргийлж ажлаа төлөвлөх шаардлагатай.

Хөрсний температур: Байгаль орчны төслөөс нөлөөлөхөд хөрсний температур нэмэлт нөхцөл бүрдүүлэх эсэхийг анхаарахын тулд хөрсний гадаргын болон гүний температурыг олон жилийн дундаж үзүүлэлтээр гаргаж дүгнэлт хийв.

Хүснэгт № 1.2. Хөрсний гадаргын температур.

Сар	Дундаж	Үнэмлэхүй бага	Үнэмлэхүй их
1	-23.9	-10.0	-31.0
2	-19.9	-2.7	-32.0
3	-8.6	7.2	20.1
4	3.6	26.8	-7.9
5	13.6	37.1	-2.5
6	19.9	43.1	8.0
7	21.4	44.0	11.5
8	19.0	38.5	9.8
9	10.9	40.7	2
10	0.6	17.8	-6.7
11	-13.2	-5.0	-18.5
12	-21.3	-12.3	-27.1

10 дугаар сарын сүүлчээс эхлэн хөрс өнгөнөөсөө хөлдөж эхлэн улмаар газрын гүн рүү нэвчиж, дараа нь 2 дугаар сард улирлын хөлдөлтийн гүндээ хүрдэг байна.

Хур тунадас: Хур тунадасны олон жилийн дундаж хэмжээ 232.1 мм бөгөөд түүний 90% нь дулааны улиралд буюу 4-9 дүгээр сард ордог байна.

Агаарын чийгшил: Агаарын харьцангуй чийг жилд дунджаар 62% ба 12, 1 дүгээр сард 70-74%, хамгийн хуурай үе болох 4 дүгээр сард 48 хувь болдог байна. Энд олон жилийн дундаж үнэмлэхүй чийгшлийн хэмжээ гПа байдаг. Үнэмлэхүй чийгшил нь усны уурын даралт агаарын температураас хамааралтайгаар өвөл 0.7-2.2 гПа, зун 8.5-13.1 гПа байна.

Цасан бүрхүүл: Цасны хамгийн их зузаан 15 см хүрдэг цасан бүрхүүлтэй өдрийн тоо жилд дунджаар 68 хоног байна. Анхны цас 9 дүгээр сард орох ба 10 дугаар сарын сүүл, 11 дүгээр сарын эхээр тогтвортой цасан бүрхүүл үүсч 5 дугаар сарын дунд болон сүүл үеэс цасгүй болдог байна.

Нар: Хамгийн богино өдөр 12 дугаар сарын 21 бөгөөд 8 цаг 24 минут үргэлжилнэ. Хамгийн урт өдөр нь 6 дугаар сарын 20-ны өдөр бөгөөд 16 цаг 02 минут байгалийн гэрэлтэй байна. Хамгийн эрт буюу 6 дугаар сарын 17-ны өдөр 4 цаг 53 минутанд нар



мандах ба хамгийн орой нар жаргах нь 6 дугаар сарын 25-ны өдөр 20 цаг 57 минутанд тохионо. Хамгийн орой нар мандах өдөр 12 дугаар сарын 31-ний өдрийн 8 цаг 43 минут бөгөөд хамгийн эрт жаргах өдөр нь 12 дугаар сарын 12-ны өдрийн 17 цаг болно.

Агаар дахь тоосжилт, бохирдолт: Төсөл хэрэгжих нутагт хүн ам цөөтэй, хүрээлэх орчны агаарт нөлөөлөх хог хаягдлын томоохон эх үүсвэр, бохирдуулагч эх үүсвэр байхгүй нутаг дэвсгэрт оршдог. Улиралын шинж чанартай бага хэмжээгээр тохиолдох шороон шуургыг л тооцохгүй бол төсөл хэрэгжих орчин нь үндсэндээ цэвэр агаартай.

1.4. Усан орчин

Бүрэгхангай сум нь Орхон Туул, Ангирт, Ямаат, Бичигт, Шувуут, Харбух зэрэг томоохон гол, горхи, булаг шандтай. Энэ бүс нутаг нь гидрогеологийн мужлалын ангиллаар Хойт Монголын гидрогеологийн системийн Хэрлэн голын грунтын усны ай савын хойт хэсэгт хамаарагдана.

Газрын доорх усны байгалийн баялаг үүсэх нөхцөл нь ус агуулагч чулуулгуудын коллектор шинж буюу шүүрүүлэгч орчны төлөв байдал, шинж чанараар тодорхойлогдоно.

Хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600 км орчим урттай, 1-4 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Гольдрол нь тохойрол, тахирлалт ихтэй, олон тооны хар ус, жижиг аралтай бөгөөд гольдролын өргөн нь 30-100 метрийн хооронд хэлбэлздэг ба голын боргио хэсэгтээ 0.6 м, тайван хэсэгтээ 3 м ба түүнээс дээш, гүн нь 0.5-1.6 м зарим газраа 2.5 м хүрдэг. Урсгалын хурд 0.3-11 м/сек, хөндийн хэвгий нь 0.001-0.002. Туул гол 10 дугаар сарын сүүлчээр хөлдөж эхлэх ба 4 дүгээр сарын эхээр гэсч эхэлдэг.

Газрын доорх ус агуулсан үе нь 6-30 метрийн гүнд орших ба ойролцоогоор 3 л/сек ундаргатай байдаг. Ажлын талбайд Туул голын баруун талын цутгалууд нь гүний хэрчигдэлд хүчтэй өртсөн бөгөөд жилийн ихэнх цагт усгүй байдаг. Тэдгээрийн урт нь 2-10 км хүртэл үргэлжилдэг. Харин зүүн талын цутгалууд нь харьцангуй бага хэрчигдсэн усгүй сайр маягийг үүсгэх ба 4-5 км үргэлжилдэг.

1.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь Хангай Хэнтийн уулархаг мужид хамрагдана. Энэ мужид Хэнтийн нуруу хийгээд түүний салбар уулс, Орхон, Туул, Хараа, Ерөө голын хөндий, мөн Эрээний нуруу, Онон, Улзын сав газар багтана. Тус мужийн төв хэсэгт хамгийн өндөр өргөгдсөн Хэнтийн гол нуруу орших бөгөөд түүнээс тал бүр тийш салбарласан уулс аажим намссаар бэсрэг уулс болон улмаар ухаа гүвээт талд шилжинэ.

Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцлийг бий болгодог бөгөөд өндөр уулын нугын хөрс голлож, уулын хүрэн, ойн саарал хөрс нилээн их тархсан чулуу, хайрга ихтэй, ялангуяа төвийн бүсэд уулын хүрэн хөрс зонхилж, өвөр талд нь цайвар хүрэн хөрс голлож, ар талаар нь ойн саарал хөрс бага зэрэг тархсан байдаг ба хөрс харьцангуй зузаан бөгөөд ялзмаг болон тэжээлийн бодис ихтэй байна.



1.6. Ургамлан нөмрөг

Судалгаа явуулсан нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их муж, чийглэгдүү хэвшинжийн Дорнод Азийн муж, Орхон-Туулын нам уулсын тойрогт хамаарагдана (Монгол улсын Үндэсний атлас, 2009). Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангайн уулт их муж, Орхон Туулын савын бэсрэг уулсын муж, Орхон-Ерөө голын тойрогт багтана (Даш, 2000).

Уурхайн олборлолт явуулж байгаа нутаг нь нам уул, уулын хээр, татмын нугын ургамалжилттай. Нэрт эрдэмтэн Дашням /1974/ энэ районы ургамалжилтыг судлаад Дагуур-Монголын хээрийн провинцийн Дашинчилэнгийн районд хамруулжээ.

Нам уулын хажуу, налуугаар шивээт хялганат, хазаар өвст, агьт, алаг өвст хээр тархахаас гадна уулын оройн хэсгээр ботуульт хээр зонхилно. Уулын хоорондох хөндийнүүдээр хялганат, хиагт, алаг өвст, харганат хээрүүд зонхилон тархдаг.

Тал хөндийн төв хэсгээр үетэн-хялганат/хялганат агь-үетэнт хуурай хээрүүд элбэг таарна. Туул голын татмын хоёр талын өргөн хөндийгөөр жижиг навчит харгана бүхий агь-хялганат хээр, мөн үхэр харгана, бүхий харгана-хазаар өвст хээр элбэг тархдаг.

Төсөл хэрэгжиж буй талбайд нийт 19 овог, 49 төрөлд хамаарагдах 58 зүйл ургамал бүртгэгдлээ. Овгуудын дотроос үетэн 15 зүйл, нийлмэл цэцэгтэн-6 зүйл, тэргүүлэгч цэцэгтэн-7 зүйлтэйгээр бусад овгийн ургамал 1-3 зүйлтэй тохиолдож байна. Түүнчлэн зүйлүүдийн дотроос мод 1 зүйл, сөөг 3 зүйл, 15 зүйл нэг наст ургамал байгаа бөгөөд 39 зүйл олон наст ургамал ургаж байна.

1.7. Амьтны аймаг

Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Монголын хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Монгол Дагуурын тойрогт хамаарна. Амьтны аймгаас нийтлэг буюу зөвхөн тал хээрийн нөхцөлд дасан зохицсон амьтад тохиолдоно. Үүнд: Туулай хэлбэртнээс бор туулай, огодой, мэрэгчдээс үлийн цагаан оготоно, махан идэштнээс саарал чоно, хярс, үнэг, шувуудаас шоорон эвэрт болжмор, монгол болжмор, шилийн сар, хөхтөн амьтнаас цагаан зээр зэрэг амьтад элбэг байна.

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт № 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Биелэлт	Фото зураг
Агаарын орчин				
1	<ul style="list-style-type: none"> Цаг уурын нөхцөл байдал, уул техникийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт үүсэх Тээврийн хэрэгслүүдээс ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох 	<p>Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийж, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах.</p>	<p>Агаарын шинж чанарыг тодорхойлох, урлирал тутамд технологийн зам, засварын талбай, кемп хэсгээс дээж авч, лабораторийн шинжилгээнд хамруулсан. Технологийн зам усалгааг баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усан сангаас авч, шаардлагатай үед усалгааг тогтмол хийлгэдэг.</p>	 



2	<p>Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, тээвэрлэлт, овоолго хийх зэрэг газар шорооны ажилтай холбоотой тоосжилт үүсэх</p> <p>Хог хаягдлын үнэр тархах</p>	<p>Хүнд машин механизмын, засвар, оношлогоо үйлчилгээ, тохируулгыг тогтсон хуваарийн дагуу тогтмол хийж, хүнд машин механизмыг жил бүр техникийн үзлэгт хамруулах.</p>	<p>Техникүүдийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, үзлэг оншилгоонд хамруулсан. Хог хаягдлын үнэр дарах зорилгоор бодисын судалгаа хийж ариутгал халдваргүйтэлийг дотооддоо тогтмол хугацаанд авч хэрэгжүүлдэг.</p>	
3	<p>Төслийн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт хорт хий газарт бууж ургамлан бүрхэвч ба хөрсөнд нөлөөлөх</p>			
4		<p>Ажилчдын эрүүл ажиллах амрах орчинг бүрдүүлэх.</p>	<p>Ажилчдын амрах өрөөнүүд болон кемп орчимд хортон шавьж устгал мэрэгч амьтан, ариутгал халваргүйтлийг тогтмол хугацаанд хийдэг.</p>	

Дуу чимээ

4	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх.	Дуу шуугианы хэмжилтийг PCE-EM 883 багажаар баяжуулах үйлдвэр, засварын талбай, уурхайн хэсэгт хийсэн.	
	Амрах уурхайн бүсэд байр, орчны	Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх	Кемпийн орчимд дуут дохио гаргахгүй байх, дотоод журамд өглөө, оройн 10 цагаас хойш ямар олныг хамарсан дуу шуугиан гаргахгүй байхыг тусгасан ба байнгын хяналт тавьж ажилладаг.	
Усан орчин				
5	Газрын доорх урсацын горим алдагдах, усны бохирдол, Шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох,	Зуны улиралд аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул уурхай, овоолго зам талбай усанд автаж болзошгүй тул үерийн уснаас хамгаалах, усыг	Уурхайн бүсэд үерийн уснаас хамгаалсан суваг шуудууг цэвэрлэж чөлөөлсөн. Төслийн талбайн ойр орчмын	



	<p>Эргэлтийн усан сангуудаар алт угаан баяжуулсан бохир ус шүүрч алдагдах</p>	<p>хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх хамгаалалтын далан шуудуу барих арга хэмжээ авах.</p>	<p>цэвэрлэгээг тогтмол хийдэг.</p>	
<p>6</p>		<p>Гүний гадаргын итгэмжлэгдсэн лабораторит Гүний тоолуурын баталгаажуулалтыг хийлгэх.</p>	<p>Худгийн ус, Туул голын ус, уурамч улрал тутамд итгэмжлэгдсэн лабраторт шинжлүүлсэн. Гүний худгийн тоолуурыг</p>	
<p>Хөрсөн бүрхэвч</p>				
<p>1</p>		<p>Тээврийн хэрэгслийг маршрутын бус</p>	<p>Тээврийн хэрэгслийн хурдыг</p>	

	<p>Уурхай ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх</p>	<p>замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах.</p>	<p>хязгаарлахаар зам талбайг тэмдэгжүүлсэн.</p>	
<p>2</p>	<p>Шатах тослох материал асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах аюултай.</p>	<p>Өнгөн хөрсийг хуулан авах, Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго үүсгэж хадгалах.</p>	<p>Үржил шимт хөрсийг хуулан авч 15,600 м3 хөрсийг шимт хөрсний овоолгод нөөцөлсөн байна.</p>	
<p>3</p>	<p>Шимт хөрсний овоолго үүсгэсний дараа хөрс сийрэгжсэн байх учир хөрс салхинд хийсэх, үерийн усанд урсах магадлалтай.</p>	<p>Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалж, уурхайн орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс саармагжуулах талбайг тэлж өргөсгөх.</p>	<p>Хаягдал тосны цэг болон, хөрс саармагжуулах талбайг сайжруулан, хөрсний бохирдлоос сэргийлж, бетонжуулсан.</p>	
<p>4</p>	<p>Машин техникийн олон салаа зам үүсч тоос шороо үүсгэх, ургамал сүйтгэх, хөрсийг халцлах аюултай</p>			



5	<p>Хөрс хатуу хог хаягдлаар бохирдох нөлөөтэй.</p>	<p>Талбайн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх.</p>	<p>Ахуйн болон аюултай хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалж, төвлөрсөн хог хаягдлыг гэрээт байгууллагуудад нийлүүлдэг.</p>	
Ургамал				
1	<p>Олборлолт, уурхайн зас-вар үйлчилгээ, уурхайд олон салаа зам үүссэнээс болж ургамлан бүрхэвч устгах нөлөөлөлтэй.</p>	<p>ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгох.</p>	<p>2019 онд төсөл эхэлхэд засварын талбай, ШТМ-ын талбай, хаягдал тосны цэг орчмыг бетонжуулсан.</p>	
2	<p>Хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас болж ургамлан бүрхэвч бохирдох, халцрах, устгах аюултай.</p>	<p>Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хог хаях нэгдсэн цэг байгуулах.</p>	<p>Хөрсөн бүрхэвчид тусгагдсан</p>	

3		<p>Жил бүр ургамлын судалгаа, мониторинг явуулах, тариалах, сэргээлтэд тохиромжтой орон нутгаас түүж бэлдэх.</p>	<p>5 дугаар сард хайлаас модны үр түүж хүлэмжинд үрслүүлэн мод үржүүлгийн талбайд суулгасан. 10 дугаар сард мандлын цэцгийн үр түүж ирэх жилийн тариалалтад нөөцөлсөн.</p>	 
4		<p>Ашиглалтын талбайн ургамлан бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, тэмдэгжүүлэлт хийх</p>	<p>Уурхайн бүс, төслийн талбайд хаяг, тэмдэгжүүлэлт бүрэн хийгддэг.</p>	
Амьтан				
1	<p>· ажиллагаа явуулсан-тай амьтны нөөц хомсдох</p> <p>· Ухсан нүх шуудуунд амьтан унах</p>	<p>Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хамгаалалтын далан шуудууг байгуулах.</p>	<p>Уурхайн талбайд мал амьтан унаж бэртхээс сэргийлэх далан хийж, мал гол руу явах зам талбайг чөлөөлж, зам дагуух тэмдэг</p>	 



2	<p>Олборлолтын үед мэрэгч, мөлхөгчидийн амьдрах орчин алга болж, тэнд үүрлэх шавжууд устгах</p>	<p>Уурхайн ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх асуудлаар мэдээллийг тогтмол өгөх.</p>	<p>тэмдэглэгээг байрлуулсан. Баяжуулах хэсгийн эргэлтийн усан санд үржсэн загасыг тор тавьж барин, туул гол руу нүүлгэн шилжүүлдэг.</p>	
3	<p>Шувуу, нүүдлийн хөхтөн амьтадын дайрч өнгөрөх зам хаагдах</p>	<p>Уурхайн орчмын тогтсон нуур цөөрөм, цэврийн нууранд үржсэн загасыг, загасны тор байршуулж туул голд нүүлгэн шилжүүлэх.</p>		
4	<p>Кемпийн орчинд өсөж торнисон амьтадыг хамгаалах</p>	<p>Кемпийн орчинд өсөж үржиж байгаа муурыг цаашид арчилж хамгаалах сонирхолтой ажилчдад үрчлүүлэх</p>	<p>Муурны өсөлтийг зогсоохын тулд эм муурнуудыг ажилчдад үрчлүүлж багасгаж байна. Кемпид хараацай шувуу ихээр үүрлэн дэлгэрч байна.</p>	
<p>Нийт: 2.630.000</p>				

2.1. Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Цаг уурын нөхцөл байдлаас уулын хэсэг, машин механизмын үйл ажиллагаа, ажилтны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Иймээс төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөлтэй тул дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Уурхайн тоосжилтыг багасгахын тулд олборлолт явуулж буй талбай, технологийн зам, гадаад овоолго, тээврийн хэрэгслийн дотоод зам талбайг графикын дагуу услаж бүртгэлжүүлж байна. Технологийн зам усалгаа хийгдэж буй байдлыг зураг 1-т харуулав.



Зураг № 2.1. Технологийн зам усалгаа хийгдэж буй байдал.

2. Шороон замыг 30- 40 см зузаантай нойтон шламаар хучиж тагтаршуулан засварлаж,
олон салаа зам гаргахгүй байх үүднээс замын тэмдэг тэмдэглэгээг хийж тээврийн хэрэгслийн хурдыг 30 милийн хурдтай явхаар журамчилж өгсөн.
3. Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд хөдөлгүүрт ашиглагдаж буй машин механизм, техникийн засвар, оношлогоо үйлчилгээ, тохируулгыг тогтсон хуваарийн дагуу тогтмол хийж, хүнд машин механизмыг жил бүр техникийн үзлэгт хамруулж байна.
4. Агаарын чанарын үзүүлэлт дээр **MNS 4585:2016** стандартын дагуу шинжилгээг Булган аймгийн итгэмжлэгдсэн лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний лабораторид өгч хийлгэхэд стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрээгүй байна.

Ил уурхайн ашиглалтын улмаас агаарт тоос их хэмжээгээр тархах үед технологийн зам усалгааг баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усан сангаас болон уурхайн шүүрлийн усыг нөөцлөн ашигладаг нь байгалийн гадаргын усны нөөцийг хамгаалах дорвитой арга хэмжээ болж байна.

2.2. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

1. Техникийн хөл хөдөлгөөнийг зориулалтын бус замаар явуулахгүй байхад нь хяналт тавин замын тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажилладаг.
2. Уурхайн үйл ажиллагааны явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөнд оруулдаг учир орчны тохижилт, ногоон байгууламжийг хийсэн.




Зураг № 2.2. Кемпийн орчны тохижилт, ногоон байгууламж.

2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор доорхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Уурхайн олборлолтод өртөх үржил шимт хөрсийг хуулан авч 10,720 м³ хөрсийг шимт хөрсний овоолгод нөөцөлж авсан. Үржил шимт хөрсний тээврийг зураг 3-т харуулав.



Зураг № 2.3. Үржил шимт хөрсийг хуулж буй байдал.

2. Үржил шимт хөрсийг хадгалахдаа 4 метрийн өндөртэй овоолго үүсгэж, 18⁰- аас хэтрүүлэхгүй хадгалж байна.
3. Олон салаа зам гаргаж хөрс талхлахаас урьдчилан сэргийлж технологийн замыг байгуулан тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.



Зураг № 2.4. Уурхайн технологийн зам арчилгаа.

4. Уурхайн олборлолтын явцад техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэржүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлтийг хийж байна.



Зураг № 2.5. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй байдал.

5. Техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт модны суулгацуудыг тариалж, биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.





Зураг № 2.6. Хөрсөн бүрхэвчийг хамгаалж биологийн нөхөн сэргээлт хийсэн байдал.

6. Ахуйн бохир усыг 100 тонны юмкосыг байрлуулж, хуримтлагдсан бохир усыг “Булган мээж” ХХК-тай хийсэн гэрээний дагуу “Шижир алт” ХХК-ийн цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг.

2.4. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

“Туулын зүүн дэнж 1-3” төсөл нь технологийн болон бусад хэрэглээнд шаардагдах, 188,928.00 м³/жил усыг Туул голоос, унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг гүний худгаас авч хэрэглэхээр ус ашиглуулах дүгнэлтийг “Усны газар”-аар гаргуулан авсан байна.

Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн “Туул голын сав газар”-т хүсэлт гаргаж ус ашиглах зөвшөөрөл болон гэрээ байгуулан ажилласан.



Зураг № 2.7. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ

Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг Туул голын сав газрын захиргаатай байгуулж, Хаягдал усны зөвшөөрлийг Усны газраас нэг жилээр сунгуулан, хэрэгжилтийг хангаж ажилсан.

Усны шинжилгээг улирал бүр Булган аймгийн Ус цаг уур орчны хяналт шинжилгээний төвийн харьяа байгаль орчны шинжилгээний лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораторид өгч шинжлүүлсэн. Усны бохирдол буюу чанарыг шинжлүүлэхээр гадаргын ус болон газрын доорх усыг хамруулсан. Усны дээж авч буй байдлыг доорх зурагт харуулав.

Гадаргын ус нь баяжуулах хэсгийн ашиглагдсан ус буюу эргэлтийн усан сан, газрын доорх ус нь ахуйн хэрэглээнд хэрэглэгддэг ундны ус юм. Ундны усны гүний нэг худагтай бөгөөд энгийн болон хамгаалалтын эрүүл ахуйн бүсийг тогтоож хашаажуулсан.



Зураг № 2.8. Усны дээжийг авч буй байдал.

Шатах тослох материал асгарч хөрсөнд нэвчин, хөрс ус бохирдуулахаас сэргийлэн шатах тослох материал түгээх цэг болон засварын газар, автомашины зогсоолын суурийг цементлэх, асгарсан тохиолдолд тухай бүр нь саармагжуулах арга хэмжээ аван ажиллаж байна.

Бохир усыг битүүмжлэл сайтай, ус нэвтрэхгүй төмөр юмкосонд хуримтлуулдаг буюу, бохирын цооногоос дээж авч шинжилгээнд хамруулсан.



Зураг № 2.9. Бохир ус соруулж буй байдал.

2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх дам нөлөөлөл нь тоосжилт юм. Хуурайшилт ихтэй, салхи шуургатай үед нарийн тоос алс хол хийсэж тархах энэ нь улмаар ургамлан нөмрөг дээр буун өнгө нь гундах, өсөлт хөгжилт нь зогсох зэрэг сөрөг нөлөөлөл гарч болзошгүй. Иймээс дараах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

1. Төслийн талбайн ургамлын мониторингийг судалгаа шинжилгээний төвөөр хийлгэж, мод үржүүлгийг уурхайн кемпэд ажлуулж, нөхөн сэргээлтэд тариалж байна. Доорх зурагт харуулав.



Зураг № 2.10. Ургамлын хэмжилт хийлгэж буй байдал.

2. ШТМ-ын агуулах болон засварын талбайг хатуу хучилттай болгож ургамлан нөмрөгийг бохирдохоос урьдчилан сэргийлж хамгаалсан.
3. Ашиглалтын талбайн ургамлан бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх үүднээс тэмдэгжүүлэлт хийж өгсөн.
4. Хог хаягдлыг төслийн талбайгаас гадагш ил задгай хаяхгүй байх ажлыг зохион байгуулж, хог хаягдлын түр цэгийг Бүрэгхангай сумын Засаг даргаас зөвшөөрөл авч байгуулсан бөгөөд хогоо Бүрэгхангай сумтай гэрээ байгуулан сумын төвлөрсөн хогийн цэгт хаяж байна.
5. Байгалийн болон нутгийн ургамлын үрийг түүж, нөхөн сэргээлтэд хэрэглэхээр бэлдэж байна.



Зураг № 2.11. Хайлаас болон мандлын цэцгийн үр түүж буй байдал.

2.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн талбайн ойр орчимд нэлээд уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа тул амьтдын тархалт харьцангуй бага. Тиймээс “Туулын зүүн дэнж 1-3 хэсэг” алтны шороон орд ашиглах төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөө харьцангуй бага байна. Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээг авч ажиллаа. Үүнд:

1. Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад онцгой анхаарч ажиллаж байна.
2. Уурхайн талбайд мал амьтан унахаас сэргийлэн хамгаалалтын далан шуудуу хийж, байнгын харуул хамгаалалттай ажиллаж байна.
3. Орон нутгийн иргэдийн мал амьтан усруу явах зам талбайг чөлөөлж, зааглаж өгсөн.



Зураг № 2.12. Мал усруу явах хэсгийг аюул эрсдэлгүй болгосон байдал.

4. Баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд гадаргын усыг соруулах үед загас нь эргэлтийн усан сан руу сорогдож түүнд үржсэн загасыг гол руу нүүлгэн шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.



Зураг № 2.13. Эргэлтийн усан санд үржсэн загасыг голруу нүүлгэн шилжүүлж буй байдал.

2.7. Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд :

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, заавар, зааварчилгааг мөрдөж ажилладаг.
2. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар “Фамили медикал” эмнэлэгтэй гэрээ байгуулж нийт 187 гаруй ажилчдыг хамрууллаа.



Зураг № 2.14. Эмчийн үзлэгт хамрагдаж буй байдал.

3. Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавьж засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэж байна.
4. Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсад нэмэгдэл цалин, урамшууллыг шат дараалалтайгаар олгож байна.
5. Төслийн талбайн ойролцоох иргэдийн өвөлжөөний бууцыг хуулж малчдад тус дэм болж ажиллаа.



Зураг № 2.15. Малчдын өвөлжөөний бууцыг хуулж өгсөн байдал.

6. Орон нутагт өгөх татвар, хураамж, төлбөр зэргийг цаг хугацаанд нь иргэдээс мах, сүү, тараг зэргийг авч иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна. 2023 оны байдлаар үхрийн мах 9315 кг, хонны мах 366 кг, сүү 1820 литр, тараг 1360 литр тус тус авсан байна.

2.8. Дуу чимээнээс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Дуу чимээнээс үзүүлэх нийт сөрөг нөлөөллийн хэмжээ харьцангуй багад тооцогддог ба ил уурхайн талбай, баяжуулах цехийн ойр орчимд ажиллаж буй ажилчид, уурхайчид тосгонд хүрч буй дуу чимээний түвшинг аль болох үндэсний стандартын хэмжээнд байх, түүнийг бууруулахын тулд хамгийн тохиромжтой нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд :

1. Уурхайн ажилчид, ил уурхай, баяжуулах цех, түүний орчимд ажиллаж байгаа ажилчдад дуу чимээний бохирдлоос хамгаалах хэрэгсэл буюу чихэвч зүүлгэх, ашиглах хэвшүүлэх зэргээр, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

2. Дуу чимээ цацруулдаг засварын хэсгийн тоног төхөөрөмж, баяжуулах үйлдвэрт дуу авианы хаалт хийж битүүмжилсэн.
3. Тоног төхөөрөмж, машин техникт байнгын үзлэг шалгалтыг хийж ажиллаж байна.

БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага бүр зохих шаардлагын хэмжээнд гүйцэтгэх үүрэгтэй.


“Туулын зүүн дэнж 1-3 хэсэг” алтны шороон ордын уурхай орчмын газрын хэвлий газрын гадарга, хөрс, гадаргын усан орчин, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын арга хэмжээг тайлагнан боловсрууллаа.

3.1. Биологийн нөхөн сэргээлт

Туулын зүүн дэнж 1-3 уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үүдэлтэй эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, эзэмшлийн талбай болон төслийн үйл ажиллагаа явуулж буй Бүрэгхангай болон хөрш Заамар сумын ногоон байгууламж бүхий орчны тохижилтод зориулан тухайн бүс нутагт ургадаг байгалийн ургамлын тарьц суулгацыг бэлтгэх зорилготой модны үрслэгчүүдийг уурхайн кемпэд, хүлэмжид, үржүүлж бойжуулалтын талбайд шилжүүлэн 2 настайд нь нөхөн сэргээлтийн талбайд шилжүүлэн суулгадаг.

Тус үржүүлгийн талбайд 2024 оны намрын тооллогын дүнд 6 зүйл ургамлын 1-4 настай 50.000 ш тарьц суулгац тоологдсон байна. 2024 оны кемп дэх мод үржүүлгийн хүлэмжийн тарилтыг 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн тариалсан.

2024 оны биологийн нөхөн сэргээлтийг жимсний аж ахуйн чиглэлээр өөрсдийн мод үржүүлгийн талбайгаас, 3 настай чацарганы суулгацыг хураан авч, хавар 4-5 сарын хугацаанд 2.2 га талбайд тариалахаар төлөвлөсөн. Биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй талбайг доорх план зурганд харуулав.



Зураг № 3.1. Биологийн нөхөн сэргээлт хийгдэхээр төлөвлөсөн талбай.

Жимсний аж ахуйн чиглэлээр тусгай зөвшөөрлийн MV-000181 талбайд 2.2га талбайд 3 настай 5000 гаруй чацарганы суулгацыг тариалсан. Усалгаанд, дуслын

системийг суурилуулж сард 3 удаа ханатал усалснаар, ургалтын явц маш сайн жилийн эцсийн байдлаар 95 хувьтай ургасан байна. Нөхөн сэргээлтийн ургасан байдал болон хийгдсэн талбайг доорх зурганд харуулав.



Зураг № 3.2. Биологийн нөхөн сэргээлт хийж буй байдал.



БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах сайжруулахад чиглэгдсэн менежментийн арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчин, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд дүйцүүлэн хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

2024 оны дүйцүүлэн хамгаалах ажлаар Булган аймгийн Бүрэгхангай суманд байрлах булгийн эхийг хашиж хамгаалахаар төлөвлөсөн. Булгийн эхийг хашиж хамгаалах үед дараах зүйлүүдийг анхаарч ажиллана. Үүнд:

1. Булгийн ундаргыг хөндөхгүй байх;
2. Орон нутагт элбэг тохиолдох өнгө үзэмжтэй чанарын шаардлага хангасан материалыг сонгох;
3. Нэг загварын хийцүүдийг өргөн ашиглах;
4. Булгийн ойролцоо өрөмдлөг, тэсэлгээний ажил хийхгүй байх;
5. Хашиж хамгаалах булгийн газрын байршлыг тухайн сумын ЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтантай явж хэмжилт хийж тэмдэгжүүлэх.
6. Булгийн хамгаалалтын ажлын гол үндсэн хэсэг болох хамгаалалтын төмөр торыг хайрцаглан бэхлэх, бетонон болон төмөр хөлийг /барилгын норм ба дүрэм/-ийг баримтлан хийнэ.
7. Булгийг хашихдаа шон хоорондын зай 3м байх бөгөөд 0.5м гүнд хөдөлгөөнгүй суулгаж явган хүн орж гарах хаалга, ус булаг шандын эхийг хайрлан хамгаалах санамж мэдээлэл бүхий самбар байрлуулсан байна.
8. Булгийн эхийг хамгаалахаар хашааг тойруулан мод тариалах.
9. Булаг хашиж хамгаалах үеийн ажлын явцын тайланг ирүүлэх.
10. Ажил гүйцэтгэж байх үеийн болон булаг хашихаас өмнөх ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч тайландаа хавсаргав.

Хүснэгт № 4.1. Булгийн эхийг хашсан ажлын зардал.

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Торон хашаа	ш	21	160,000	3,360,000
2	Хашааны шон	ш	20	70,000	1,400,000
3	Самбар	ш	1	300,000	300,000
Нийт: 5,060,000					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд, Булган аймгийн Бүрэгхангай сумын дэрст багт байрлах “Ар тээлийн адаг” булгийн эхийг хашиж хамгаалахаар төлөвлөсөн. Тухайн булаг нь Бүрэгхангай сумын төвөөс хойшоо 20 км-т байрлах ба, булгийн эхээс мал амьтан ус уудаг байсан.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 8 дугаар сард хийж гүйцэтгэн, нийт 200 м2 талбайг хамруулан 1,5 метрийн өндөртэй, 60 метр хашааг барьж, булгийн эхийг хашиж хамгааллаа. Тухайн булаг нь ойрхон газар хоёр хэсэгт оргилж байсан ба тус тусад нь хашиж хамгааллаа. Эхийг хашиж хамгаалсан ажлын үйл явцыг доорх фото зурагнуудад харууллаа.



Зураг № 4.1. Булгийн эхийг хашиж орон нутагт хүлээлгэн өгөө.



БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Туулын зүүн дэнж 1-3 хэсэг алтны шороон ордын талбайн ойр орчим нөлөөллийн бүсэд айлын өвөлжөө, хаваржаа бүхий газартай давхцаагүй учир нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажил хийгдэхгүй болно.

БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛСТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ

“Платинум ланд” ХХК-ийн 2024 оны ашиглалтанд өртсөн талбайд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна.

Төсөл хэрэгжүүлэх газарт нутагт ШУТИС-ын Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн хүмүүнлэгийн ухааны салбарын мэргэжилтнүүдээр археологийн хээрийн судалгааны ажлыг хийлгүүлэн тайлан гаргуулсан. Мөн ШУТИС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвөөр палеонтологийн хайгуул, судалгааны ажлыг хийлгүүлэн тайлан гаргуулсан.

Дээрх археологи, палеонтологийн судалгаагаар тусгай зөвшөөрлийн талбайд ямар нэгэн түүх соёлын өвийн эд өлгийн зүйл илрээгүй бөгөөд ашиглалтын үйл ажиллагаа явуулахад археологи, палеонтологийн зүгээс харшлах зүйл байхгүй гэсэн дүгнэлтийг гаргасан.

Цаашид компанийн эзэмшиж буй ашиглалтын талбайг ашиглах явцад Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудыг биелүүлж, МУИС-ийн НШУС-ийн Археологийн Антропологийн тэнхим, ШУА –ийн Археологийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Үндэсний музей зэрэг эрх бүхий мэргэжлийн байгууллагад хандаж, археологийг авран хамгаалах малтах, судалгаа хийлгэж, хамгаалалтын арга хэмжээг авна.

БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт № 7.1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Фото зураг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1		<ul style="list-style-type: none"> - Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж, машин механизмыг жил бүр үзлэг оношилгоонд оруулж, технологийн зам усалгааг тогтмол хийж хэвшсэн. 		Тогтмол
2	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	<ul style="list-style-type: none"> - Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр ангийн Захирагч, Хурандаа Д.Гантулгаар батлуулан ажилласан. - Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг Булган аймгийн ОБГ-аар батлуулан ажилласан. 		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө
		<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны үзлэгийг хэсэг нэгж бүр дээр тогтмол хийж, илэрсэн зөрчлийн хариу арга хэмжээг авч ажилладаг. 		Сард 2 удаа
3				

- Ослоос урьдчилан сэргийлэхийн тулд ажилчдад аюулгүй ажиллагааны зааврыг өгч, гарын үсэг зурж баталгаажуулдаг.
- Эрсдэлтэй ажилбар хийх үед, эрсдэлийн үнэлгээ хийж аюулыг тодорхойлсны дараа ажлыг зохион байгуулдаг.
- Булган аймгийн онцгой байдлын газраас сургалтыг зохион байгуулсан.
- Гар утас хэрэглэх үеийн журам боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилладаг.

Булган аймгийн ОБГ-ын Эрэн хайх аврах салбарын захирагч х/ч Ж.Лхагважаргал ахалсан 4 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр:

1. Амилуулах эмнэлгийн анхны тусламж
2. Нурангийн үед эрэн хайх, аврах ажиллагаа
3. Аврах ажиллагааны хэрэгслүүдийг ашиглах / усны хантааз, аврах цагираг, аврах олс, өндөрийн бүс /
4. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах арга зүй
5. Ахуйн шингэрүүлсэн хий ашиглалт зэрэг

сэдвийн хүрээнд танхимын 5 цагийн дадлага сургалтыг зохион байгуулж явуулсан.

Сургалтанд уурхайн хэсэг нэгжүүдийн А, В, ээлжний 70 гаруй ажилчид хамрагдлаа.

-



8 дугаар сард

Нийт: 1.000.000 төгрөг

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт №8.1. Хог хаягдлын сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө.

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, арга хэмжээ	Биелэлт	Фото зураг
Ахуйн хог хаягдал	<p>Хуурай хог хаягдал хаях цэгийн өнгөн хөрсийг хуулж 10-20 см зузаан бетонон хучилт хийж ус нэвчүүлэхгүйгээр тусгаарлаж, салхиар орчинд тарахгүйгээр битүүмжлэгдсэн, ангилан ялгаж хийх боломжтой байгууламж хийх.</p>	<p>Ахуйн хог хаягдлын цэгийг энгийн болон хуванцар, хоолны хаягдал зэргээр ангилан ялгаж нийт 5320 кг хог бүртгэгдсэн байна.</p>	
	<p>Сум дүүргийн засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжээр тогтмол хугацаанд хогоо ачуулах.</p>	<p>Ахуйн хог хаягдлыг Бүрэгхангай сумын засаг даргатай гэрээ байгуулж, төвлөрсөн хог хаягдлыг, сумын</p>	
	<p>Галын аюулаас хамгаалах анхааруулга санамж, зурагт хуудас, тэмдэг, тэмдэглэгээг хийж тавьсан.</p>	<p>хогийн цэгт буулгаж, гэрээний төлбөрийг тухай бүрт нь тушшаасан.</p>	
	<p>Хатуу болон шингэн хаягдлын цэг, түүний орчимд тогтмол ариутгал хийх.</p>	<p>Ахуйн хог хаягдлын орчимд ариутгал халдваргүйжүүлэлт, тогтмол хийдэг.</p>	



<p>Аюултай хог хаягдал</p>	<p>Химийн бодис болон шатах, тослох материал алдагдахаас сэргийлэн гаднах талбайд бетонон хучилт хийх.</p> <p>Бохирдсон хөрсийг саармагжуулах талбайн хүрээг томсгох, хөрс саармагжуулах хольц материалыг талбайд байршуулах</p>	<p>Засвар, бүтээц, ШТС, ШТМ-ын хэсгүүдийг бохирдлоос урдчилан сэргийлж бетонжуулсан.</p> <p>Хаягдал тосны цэг, хөрс саармагжуулах талбайг өргөсгөж бетонжуулан, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.</p>	
	<p>Эмнэлгийн хог хаягдлыг Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төвтэй гэрээг байгуулах.</p> <p>Аюултай хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагуудтай хийж, шаардлагатай үед нийлүүлэн, хаягдлыг бүртгэлжүүлэх.</p>	<p>Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулан хог хаягдлыг тухай бүрт нь тушааж, төлбөрийг барагдуулсан.</p> <p>Аюултай хог хаягдлын гэрээг Түмэн эгшиг ХХК-тай байгуулан, хог хаягдлыг тушааж байна.</p>	
<p>Нийт: 5.700.000</p>			

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн дагуу байгалийн бүрдэл тус бүрээр орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.


Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар давхар гүйцэтгүүлэх, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилладаг. Бид орчны хяналт шинжилгээний хүрээнд Агаар, Хөрс, Ургамал, Амьтан, Газрын доорх усанд тодорхой давтамжтай хяналтын ажлыг гүйцэтгэдэг.

9.1. Агаарын чанарын хяналт

Цаг уурын нөхцөл байдлаас уул, техникийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Иймээс төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөлтэй тул дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Уурхайн тоосжилтыг багасгахын тулд олборлолт явуулж буй талбай, гадаад овоолго, тээврийн хэрэгслийн дотоод зам талбайг графикийн дагуу усалж байна. Энэ жил 12.050 тонн усыг зам усалгаанд зарцуулсан байна. Зам усалгаа хийгдсэн усны зарцуулалтыг доорх графикаас харна уу.

График № 9.1. Зам усалгаа хийгдсэн усны зарцуулалт.



Зураг № 9.1. Технологийн зам усалгаа хийгдэж буй байдал.

Агаарын шинжилгээг улирал бүр Булган аймгийн Ус цаг уур орчны хяналт шинжилгээний төвийн харьяа байгаль орчны шинжилгээний лаборатори, Байгаль орчны судалгаа шинжилгээний төвд өгч тогтмол шинжлүүлсэн.

9.2. Усны эрүүл ахуй, чанар:

Усны бохирдол буюу чанарыг шинжлүүлэхээр гадаргын ус болон газрын доорх усыг хамруулсан. Гадаргын ус нь баяжуулах хэсгийн ашиглагдсан ус буюу эргэлтийн усан сан, газрын доорх ус нь ахуйн хэрэглээнд хэрэглэгддэг ундны ус юм. Ундны усны гүний нэг худагтай бөгөөд энгийн болон хамгаалалтын эрүүл ахуйн бүсийг тогтоож хашаажуулсан.



Зураг № 9.2. Гадаргын болон гүний уснаас дээж авч шинжилгээнд хамруулсан байдал.

9.3. Хөрсний эрүүл ахуй, чанар:

Хөрсөн дэх хүнд металлын агууламж, элементийн хувь, хөрсний химийн үндсэн үзүүлэлт, хөрсний механик бүрэлдэхүүний хувийг тодорхойлсон шинжилгээг улирал бүр Булган аймгийн Ус цаг уур орчны хяналт шинжилгээний төвийн харьяа байгаль орчны шинжилгээний лаборатори, байгаль орчны судалгаа шинжилгээний төвд өгч тогтмол шинжлүүлсэн. Нийт 13 цэгээс хөрсний дээжийг авч шинжилгээг хийлгэн, хөрсөн дэх агууламжууд зөвшөөрөгдөх хэмжээнд байна.



Зураг № 9.3. Засвар болон хог хаягдлын цэгээс дээж авч шинжилгээнд хамруулсан байдал.

БҮЛЭГ 10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай компани нь “Нийгмийн хариуцлагаараа бусдыг үлгэрлэн манлайлж, Монгол Улсынхаа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулан бүхий л үйл ажиллагаагаа үндэсний болон олон улсын жишигт нийцүүлж, өрсөлдөхүйц компани болох”-ыг үндсэн зорилгоо болгон ажиллаж ирсэн.

Өнгөрсөн жилүүдэд манай компани нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, байгаль орчин, уул уурхайн холбогдох хууль тогтоомжуудаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн уул уурхайн эдэлбэр газрын нөхөн сэргээлтийг бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад үлгэр жишээ болохуйцаар гүйцэтгэж байгааг төрийн захиргааны холбогдох байгууллагуудаас үнэлэн улсын хэмжээнд “Тэргүүний нөхөн сэргээлт” хийсэн аж ахуйн нэгжээр 5 удаа тодорч шагнагдсан билээ.

Бид үйл ажиллагааны төлөвлөгөөндөө байгаль орчны ISO-14001 стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ISO-45001 стандартын баталгаажуулалтыг хийлгэхээр төлөвлөсөн ба, төлөвлөгөөний хэрэгжилтийг дугаар сарын 10-20 ны хугацаанд компаний хүрээнд хийлгэсэн.

Энэ жилээс компаний үйл ажиллагааны чанарыг стандартад нийцүүлэхээр чанарын стандарт болох ISO-9001 стандартыг нэвтрүүлэхээр ажилласан. Стандартын шалгалтын хариу одоогоор хянан шалгагдаж байна. Шалгалтын үеэр хийгдсэн фото зургийг доор хавсаргав.



Зураг №10.1. Олон улсын аудитын шалгалтын үйл явц.

Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмолж явуулж, нийт ажилтны сургалтыг, “Монголын цахим институт” төрийн бус байгууллага, онцгой байдлын сургалтыг Булган аймгийн онцгой байдлын газраас тус тус зохион явуулсан байна.

“Монголын цахим институт” ТББ-аас 12 цагийн сургалтыг зохион байгуулж, 2024 оны 3-р сарын 14- 29-ний өдрүүдэд уурхайн 4 ээлжийн ажилтнуудыг хамруулан 2 удаа зохион явуулж нийт 158 ажилтан хамрагдсан байна.

“Монголын цахим институт” ТББ – ын багш Батбаатар, Дашцэрэн нар доорх сэдвүүдээр сургалтыг зохион явуулсан ба, сургалтын төгсгөлд сургалтаас авсан мэдлэгийг дүгнэх зорилгоор тестээр шалгалт авч баталгаажуулсан. Үүнд:

1. ХАБЭА шинэчилсэн хууль, дүрэм, журам, стандарт
2. Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалсан өвчин /МШӨ /
3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх
4. Ажлын байрны эрсдлийн үнэлгээ
5. Ажлын аюулын шинжилгээ хийх
6. Хувийн хамгаалах хэрэгсэл түүний ач холбогдол
7. Осолдогсдод үзүүлэх эмнэлэгийн анхан шатны тусламж
8. Ажлын байран дахь галын аюулгүй ажиллагаа




Зураг №10.2. “Монголын цахим институт” ТББ-ын сургалтын үйл явц.

Сургалтын ач холбогдол, үр дүн:

Мэргэжлийн байгууллагаас ХАБЭА чиглэлээр явуулсан энэхүү сургалтанд уурхайн нийт ажилтнууд хамрагдсанаар ХАБЭА-н тодорхой мэдлэг авч, болзошгүй аюултай тохиолдлын үед эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх, шуурхай ажиллагааг хангах талаар тодорхой мэдлэг, дадал эзэмшсэн байна.

Булган аймгийн Засаг даргатай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд хийгдсэн ажлын төлбөрийг шийдвэрлэж, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн.

Мөн булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг даргатай байгуулсан нийгмийн хариуцлагын хүрээнд 100 /сая/ төгрөгийг орон нутгийн төрийн санд хийсэн байна.



Зураг № 10.3. Нийгмийн хариуцлагын гэрээ.

БҮЛЭГ 11.2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тайлагнана.

Бүрэгхангай сумын дэрст багийн иргэдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулж, өнгөрсөн жилүүдийн байгаль орчны үйл ажиллагааг товчхон танилцуулсан. Дэрст багийн хурал нь сумын төвд зохион байгуулагдаж, 4 аж ахуйн нэгж танилцуулгаа тавьж, 50 гаруй иргэн оролцсон бөгөөд хурлын үеэр манай компанийг “Шилдэг хандивлагч” аж ахуйн нэгжээр шалгарууллаа.



Зураг № 11.1. Багийн хуралд танилцуулгаа тавьж буй байдал.

Булган аймгийн байгаль орчны газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг, биологийн нөхөн сэргээлтийн модны амьдралтын хувийг тодорхойлон, газар дээр нь биечлэн танилцаж, баримт бичгийн бүрдэлийг хянан шалгаж, хэсэг нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцлаа.



Зураг № 11.2. Булган аймгийн байгаль орчны газрын ажлын хэсэг нөхөн сэргээлт хэсэг нэгжийн үйл ажиллагаатай танилцсан байдал.

Туул голын сав газрын захиргаанаас 10 дугаар сарын 25 ны өдөр хяналт шалгалт ирж, уурхайн үйл ажиллагаа усны хэрэглээ бохирдлын талаар хянан шалгаж, холбогдох баримт бичгийн бүрдлийг шалгалаа.



Зураг №11.3. Туул голын сав газрын захиргаанаас хяналт шалгалтыг явуулсан байдал.


БҮЛЭГ 12. ТЭР БУМ МОДНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилснаар “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд манай компани нь Булган аймгийн Бүрэгхангай сумын төвд мод тариалахаар БОМТ-нд тусгасан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахаар, 2024 оны 9 дүгээр сарын 25 аас намрын тариалалтыг хийхээр, өөрсдийн мод үржүүлгийн талбайгаас 3 настай суулгацуудыг хурааж авсан. Үйл явцын фото зургийг доор харуулав.



Зураг №12.1. Мод үржүүлгийн талбайгаас суулгац хурааж буй байдал.

Тарилтыг Бүрэгхангай сумын шивэртэйн голын эрэг дагуу төлөвлөж, 10 дугаар сарын 1 ээс тарилтын ажлыг эхлүүлсэн. Нийт 30 га талбайд намрын тариалалт хийхээр төлөвлөж, зургийг боловсруулсан. Тарилт хийх газрын байршлыг доор зурагт харуулав.



Зураг №12.2. Бүрэгхангай суманд мод тарих газрын байршил.

Тарилтын бэлтгэл ажилд техникээр зогоон татуулж, 30 га талбайн 70 хувьд нь жимсний аж ахуйн чиглэлээр 28.000 ширхэг чацарганын мод тариалж, төгөл үүсгэсэн ба, агч модыг 30 хувьд нь буюу 12.000 ширхгийг ойн зурвас үүсгэх зорилгоор тариалсан байна. Тарилтыг 10 дугаар сарын 25-ыг хүртэл хийсэн.



Зураг №12.3. Мод тарьж буй байдал.

Нийт 30 га талбайд тариалсан төгөлүүдийг бүхэлд нь хашиж хамгаалахаар 3 км бэлчээрийн торон хашааг барьж, модны хамгаалалтыг хийлээ. Цаашид модны суулгацуудыг байгальд дасан зохицох хүртэл нь арчлан хамгаалж, намрын цэнэг усалгааг хийсэн байна.



Зураг №12.4. Хашаа хамгаалалтыг хийж, модны усалгаа хийж буй байдал.

Хүснэгт №12.1. Бүрэгхангай суманд мод тарьсан ажлын зардал.

№	Нэр, төрөл	Ажиллах хүчин	Бараа, материалын тоо, ширхэг	Зардал /сая.төг/	Гүйцэтгэх хугацаа
1	Хашааны материал	-	110	13,900,000	30 хоног
4	Ажиллах хүчин	4-6 хүн	-	Үйл ажиллагааны төсвөөс	
5	Тээврийн зардал /түлш/	-	УБ- Бүрэгхангай		
6	Хоол хүнс	4-6 хүн	-	Мод үржүүлгийн талбайгаас	
7	Чацаргана	-	28,000		
8	Агч	-	12,000		
Нийт: 13.900.000					

Мод үржүүлгийн аж ахуй

Манай байгууллага нь 2016 оноос мод үржүүлгийн аж ахуйг уурхайн кемпэдээ ажлуулж ирснээс хойш энэ оныг хүртэл 450 мянга гаруй модны үрсэлгээг ургуулж ирсэн байна.

Мод үржүүлгийн аж ахуйг бий болгосноор нөхөн сэргээлтийн талбайн суулгацыг чанартай тариалах, кемпийн ногоон байгууламжийг өөрсдийн суулгацаар тохижуулах, сум орон нутгийн ногоон байгууламжийн ажилд хувь нэмрээ оруулах,

Улаанбаатар хотын ногоон байгууламжид мод бутыг нийлүүлэх, Монгол орны модлог ургамлын тоог нэмэгдүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хийгдэх модны суулгацын нөөцийг бүрдүүлэхэд гол зорилго болгон ажиллаж байна.

Энэ онд мод үржүүлгийн хүлэмжүүдэд хавар үрээр тариалалт хийхдээ агч, шар хуайс, голт бор, нохойн хошуу, хайлаас, өрөл зэрэг 6 төрлийн үрийг хүлэмжид 5 дугаар сарын эхээр суулгаж, усалгаа арчилгааг тогтмол хийж гүйцэтгэлээ.

2010 оны нөхөн сэргээлтийн талбайгаас 15,000 ширхэг улиасны мөчрийг бэлтгэн гадаа талбайд тариалалт хийж, 98 хувийн ургалттай ургацыг авсан байна.

Намрын тооллогын дүнд хүлэмжүүдээс 6 төрлийн 30,000 гаруй үрслэгээг, гадаа буюу бойжуулах талбайгаас 14,700 ширхэг үрслэгээг хурааж аван нийт 44,700 ширхэг үрслэгээг, бойжуулах талбай руу шилжүүлэн суулгалаа.



Зураг № 12.5. Мод үржүүлгийн ажлын үйл явц.



Хүснэгт № 12.2. Модны үрийн зардал.

№	Үрийн төрөл	Тоо	Хэмжих нэгж	Үнэ
1	Агч	2	кг	160,000
2	Өрөл	2	кг	300,000
3	Шар хуайс	2	кг	Мод үржүүлгийн талбайгаас
4	Хайлаас	1	кг	
5	Нохойн хошуу	500	гр	
6	Голт бор	1	кг	
Нийт: 460,000				

**БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ
ЗАРДАЛ**

Хүснэгт № 13.1. БОМТ-ний төсвийн задаргаа.

№	Зардлын утга	Нийт зардал, төгрөг
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал		
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	2'630'000
2	Нөхөн сэргээлт	Үйл ажиллагааны зардал
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	5'060'000
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,000,000
7	Хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	5'700'000
8	Мод үржүүлгийн аж ахуй	460,000
9	Тэр бум модны хүрээнд хийгдсэн ажлын зардал	13,900,000
Нийт		28'750'000



Менежментийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал		
10	Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	7'000'000
11	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх ажлын зардал	1,500,000
Нийт 7'500'000		
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал		
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал	4'546'200
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН 41'796'200		

Нийт төсөв:

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал **41'796'200** төгрөг байна. Үүнээс:

1. БОМТ-ний нийт зардал: **28'750'000** төгрөг
2. ОХШХ-ийн нийт зардал: **4'546'200** төгрөг
3. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал: **8'500'000** төгрөг



ДҮГНЭЛТ

Туулын зүүн дэнж 1-3 уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үүдэлтэй эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, эзэмшлийн талбай болон төслийн үйл ажиллагаа явуулж буй Бүрэгхангай болон хөрш Заамар сумын ногоон байгууламж бүхий орчны тохижилтод зориулан тухайн бүс нутагт ургадаг байгалийн ургамлын тарьц суулгацыг бэлтгэх зорилготой модны үрслэгээнүүдийг уурхайн кемпэд, хүлэмжид, үржүүлж бойжуулалтын талбайд шилжүүлэн 2 настайд нь нөхөн сэргээлтийн талбайд шилжүүлэн суулгадаг.

Мод үржүүлгийн хүлэмжүүдэд хавар үрээр тариалалт хийхдээ агч, шар хуайс, голт бор, нохойн хошуу, хайлаас, өрөл зэрэг 6 төрлийн үрийг хүлэмжид 5 дугаар сарын эхээр суулгаж, усалгаа арчилгааг тогтмол хийж гүйцэтгэсэн байна.

2010 оны ойжуулалтын чиглэлээр хийсэн биологийн нөхөн сэргээлтийн талбайгаас 15,000 ширхэг улиасны мөчрийг бэлтгэн гадаа талбайд тариалалт хийж, 98 хувийн ургалттай ургацыг авсан байна.

Намрын тооллогын дүнд хүлэмжүүдээс 6 төрлийн 30,000 гаруй үрслэгээг, гадаа буюу бойжуулах талбайгаас 14,700 ширхэг үрсэлгээг хурааж аван нийт 44,700 ширхэг үрслэгээг, бойжуулах талбай руу шилжүүлэн суулгасан.

Жимсний аж ахуйн чиглэлээр тусгай зөвшөөрлийн MV-000181 талбайд 2.2га талбайд 6,600 м³ хөрсийг 20-30 см зузаантай хучилт хийж, 3 настай 5000 ширхэг чацарганы суулгацыг тариалсан. Усалгаанд, дуслын системийг суурилуулж 5-9 сар хүртэл, сард 3 удаа ханатал усалснаар, ургалтын явц маш сайн жилийн эцсийн байдлаар 95 хувьтай ургасан байна.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд, Булган аймгийн Бүрэгхангай сумын дэрст багт байрлах, “Ар тээлийн адаг” булгийн эхийг 2024 оны 8 дугаар сард хийж гүйцэтгэн, нийт 200 м² талбайг хамруулан 1,5 метрийн өндөртэй, 60 метр хашааг барьж, булгийн эхийг хашиж хамгаалсан. Тухайн булаг нь ойрхон газар хоёр хэсэгт оргилж байсан ба тус тусад нь хашиж хамгаалсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд манай компани нь 10 дугаар сарын 1-25 ыг хүртэл 30 га талбайд 40.000 ширхэг 3 настай 2 төрлийн суулгацуудыг тариалж, намрын цэнэг усалгааг хийсэн. Нийт талбайн 70 хувьд нь жимсний аж ахуйн төгөл үүсгэхээр 28.000 ширхэг чацарганын суулгацуудыг тариалж, 30 хувьд нь ойжуулалтын чиглэлээр 12.000 ширхэг агч модны суулгацуудыг тариалсан.

Мод тарьсан талбайг төгөл тус бүрээр нь 2 хэсэг хувааж аван хэсэгчлэн хашиж, нийт 3 км бэлчээрийн торон хашааг барьж, мал амьтнаас хамгаалан Засаг даргад хүлээлгэн өглөө. Бүрэгхангай сум талаас сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, нар хийсэн ажлуудыг газар дээр үзэж танилцлаа.

Төслөөс байгаль орчинд үзүүлж болох сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж ажилсан.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:.....Э.ЧИНБАТ